



**БУЛГАН АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 04 сарын 21-ны өдөр

Дугаар А-05

Булган

**Үлийн цагаан оготной тэмцэх ажлыг
зохион байгуулах тухай**

Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2 дах заалт, Засгийн газрын "Бэлчээр хамгааллын ажлыг эрчимжүүлэх тухай" 185 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А/89 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны А/169 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Бэлчээрийн талбайд байгальд халгүй аргаар үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээг зохион байгуулах сумдын талбайн хэмжээ, шаардагдах төсвийг нэгдүгээр хавсралтаар, хяналт тавих зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Арга хэмжээг хэрэгжүүлэх сумдтай гэрээ байгуулах, ажлын хэсэг томилуулах, сургалт явуулах, холбогдох мэргэжилтнүүдийг сум хариуцуулж ажиллуулах, ажлын явц гүйцэтгэлд хяналт хийлгэх, техникийн үр дүнг тодорхойлох, дүгнэлт гаргуулах, тайлан мэдээ судалгаа, акт материалыг зааврын дагуу бүрдүүлэх ажлыг хугацаанд нь чанартай зохион байгуулахыг Мал үржлийн албаны дарга /М.Жавзандолгор/-д даалгасугай.

ДАРГА

Ч.АМГАЛАН

4316100664
8014003